

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Даатгалын тухай хуулийн 14.2.2. дугаар заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Даатгалын компани нь даатгуулагчийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй байвал зохино.
- 1.3. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээгээр тодорхойлно.
- 1.4. Даатгалын компанийн төлбөрийн чадварыг тогтооход аудитораар баталгаажуулсан тайлан тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

- 2.1. Даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээ буюу төлбөрийн чадварын үзүүлэлт нь орлогод тооцсон хураамжийн 150 хувиас багагүй байна.
- 2.2. Төлбөрийн чадварын үзүүлэлт нь энэ журмын 2.1-д заасан доод хэмжээнээс бага байвал тухайн даатгалын компанийг төлбөрийн чадваргүй гэж үзнэ.
- 2.3. Даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээг дараах байдлаар тооцно:
A=B-B-Г
A - Даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээ
B - Нийт хөрөнгө
B - Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө
Г - Тохиргоо хийгдсэн дүн
- 2.4. Энэ журмын хавсралтаар батлагдсан тайлангийн маягтын дагуу даатгалын компанийн төлбөрийн чадварыг тооцно.

ГУРАВ. ЗӨВШӨӨРӨГДӨХГҮЙ ХӨРӨНГӨ

- 3.1. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгөд дараах хөрөнгүүд тооцогдоно:
 - 3.1.1. Биет бус хөрөнгө
 - 3.1.2. Бараа материал

3.1.3. Урьдчилж төлсөн зардал (тооцоо)

3.1.4. 180 хоногоос дээш хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага

ДӨРӨВ. ТОХИРГОО ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ

4.1. Зохих хувиар бууруулан тооцсон дараах хөрөнгүүдийг тохиргоо хийгдсэн хөрөнгө гэнэ.

4.1.1. Бэлэн мөнгө, банкны харилцахдансанд байгаа мөнгө,

Засгийн газрын өрийн бичиг, Төв банкны үнэт цаас 0%

4.1.2. Банкны хадгаламж, хадгаламжийн сертификат 2%

4.1.3. Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг 5%

4.1.4. Үл хөдлөх хөрөнгө 5%

4.1.5. Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 8%

4.1.6. Орон нутгийн засаг захиргааны бонд 10%

4.1.7. Компанийн бонд 10%

4.1.8. 180 хоногоос доош хугацаанд
төлөгдөөгүй байгаа авлага 20%

4.1.9. Эд хогшил, тоног төхөөрөмж 20%

4.1.10. Зээл 20%

ТАВ. ХЯНАЛТ ТАВИХ

5.1. Даатгалын компани нь их хэмжээний гэрээ байгуулах тухай бүрт төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцож байх бөгөөд хэрвээ төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд /цаашид Хороо гэнэ/ ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

5.2. Даатгагч төлбөрийн чадварын тайланг энэ журмын хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр Хорооны даатгалын хяналтыг хэрэгжүүлж буй нэгжид /Мониторинг судалгааны газар/-т ирүүлнэ.

5.3. Даатгагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Хорооны хяналт шалгалтын газар болон даатгалын хяналтыг хэрэгжүүлж буй нэгж /Мониторинг судалгааны газар/-аас Даатгалын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн холбогдох заалтуудын дагуу албадлагын арга хэмжээ авах саналыг Хороонд оруулна .

--ooOoo--

"ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ"-ЫН ЖУРМЫН ХАВСРАЛТ

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЙЛАН

ДААТГАЛЫН КОМПАНИЙН НЭР
ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА

(мянган төгрөгөөр)

1	ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ	
2	ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ / (2) = (1) x 150% /	-

(мянган төгрөгөөр)

ЗҮЙЛ		ДҮН
3.	НИЙТ ХӨРӨНГӨ	
4.	ЗӨВШӨӨРӨГДӨХГҮЙ ХӨРӨНГӨ	-
5.	ТОХИРГОО ХИЙГДСЭН ДҮН	-
6	БАЙВАЛ ЗОХИХ ХАМГИЙН БАГА ХӨРӨНГӨ / (6) = (3)-(4)-(5) /	-
7	ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ / (7) = (6) - (2) / (0- ЭЭС ИХ)	-
8	ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА / (8) = (6) / (2) (ЗОХИСТОЙ ХАРЬЦАА 100% -ИАС ИХ)	

ЗӨВШӨӨРӨГДӨХГҮЙ ХӨРӨНГӨ

(мянган төгрөгөөр)

ЗҮЙЛ		ДҮН
БИЕТ БУС ХӨРӨНГӨ		
БАРАА МАТЕРИАЛ		
180 ХОНОГООС ДЭЭШ ХУГАЦААНД ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА АВЛАГА		
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО		
ДҮН		-

ТОХИРГОО ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ

(мянган төгрөгөөр)

ЗҮЙЛ	ДҮН	БУУРУУЛАХ ХУВЬ	ТОХИРГОО ХИЙГДСЭН ДҮН
БЭЛЭН МӨНГӨ, ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БИЧИГ, ТӨВ БАНКНЫ ҮЦААС		0%	-
БАНКНЫ ХАДГАЛАМЖ, ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ		2%	-
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЛИЗИНГ		5%	-
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ		5%	-
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨӨР БАРЬЦААЛСАН ҮНЭТ ЦААС		8%	-
ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БОНД		10%	-
КОМПАНИЙН БОНД		10%	-
ЗЭЭЛ		20%	-
180 ХОНОГООС ДООШ ХУГАЦААНД БАЙГАА АВЛАГА		20%	-
ЭД ХОГШИЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ		20%	-
ДҮН	-		-

ЗАХИРАЛ

()

(гарын үсэг)

НЯГТЛАН БОДОГЧ

()

(гарын үсэг)